



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 7/309

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан Баян-Агт сумын Баян, Баяннуур сумын Дал, Булган сумын Ачуут голын эхийг хашиж хамгаалах судалгаа, зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Жишиг проект" ХХК-тай 7 000 000 /долоон сая/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай.
2. Ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, чанарын өндөр түвшинд хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.
3. Энэхүү ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу 2018 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ

